



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 28-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Орон нутгийн Хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах Нийслэл, дүүргийн Сонгуулийн хорооны зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2023/53-18-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: НТАГ-2023/53/18-ШТА-ГА

Улаанбаатар хот
2023 он

Аудитын нэгдүгээр хэлтэс
Хэлтсийн дарга,
аудитын менежер:
Д.Ичин
Ахлах аудитор:
С.Лхагвасүрэн

Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г
корпус 524 дүгээр өрөө. Утас 315578
Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна
уу. Цахим хуудас <http://niislel.audit.mn/>

АГУУЛГА

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын тушаал	4
Товчилсон үгийн жагсаалт	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	6-7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	8
БҮЛЭГ 1 Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн зардлын төлөвлөлт, улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үндэслэлтэй хуваарилсан эсэх.	8-9
БҮЛЭГ 2. Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан эсэх	9-10
Аудитын дүгнэлт	11

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын нэр:

Орон нутгийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл

Аудитын код:

НТАГ-2023/53-18-ШТА-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11, хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/61 дугаарын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хуульд заасны дагуу хийгдэх аудитыг тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Орон нутгийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

- > Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийн зардлын төлөвлөлт, улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үндэслэлтэй хуваарилсан уу?
- > Орон нутгийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан уу?

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Нийслэлийн болон Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан, холбогдох анхан шатны баримтыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн гаргасан Монгол Улсын Төрийн аудитын стандарт /MNS:6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS:6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS:6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”/-д заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулж, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага, дүн шинжилгээ хийх, аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- > Төрийн аудитын тухай хууль;
- > Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль;
- > СЕХ-ны 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”
- > Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоол;
- > СЕХ-ны Ажлын албаны баталсан төсвийн хуваарь;
- > Холбогдох бусад хууль эрхийн актууд

Аудитын хугацаа:

Аудитыг 2023 оны 08 дугаар сарын 25-аас 09 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг НТАГ-ын Аудитын удирдлага зохицуулалтын хэлтсийн ахлах аудитор С.Лхагвасүрэн гүйцэтгэж, үе шатны хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер Д.Ичин, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн

Ерөнхий мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон гарах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Аймаг, нийслэлийн Сонгуулийн хороо нь уг хуулийн 16.2.10-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах үүрэгтэй.

Аудитад Нийслэлийн болон Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан, холбогдох анхан шатны баримтыг хамруулсан.

СЕХ-ноос нийслэлийн Сонгуулийн хороонд нөхөн сонгуулийн санхүүжилтэд **23,855.0** мянган төгрөгийг төлөвлөж, хуваарилснаас **21,633.5** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт болох **2,221.4** мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХЭСГИЙН ХОРООДОД ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН УУ?

Орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Улсын төсвөөс санхүүжүүлсэн орон нутгийн нөхөн болон дахин сонгуулийн зардлыг СЕХ-оос нийслэлийн сонгуулийн хороонд хуваарийн дагуу бүрэн олгосон уу?

СЕХ-оос нөхөн сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон төлөвлөж, хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 3/240 тоот албан бичгээр 23,855.0 мянган төгрөгийн төсвийн санхүүжилтийн хуваарийг баталж төсвийг хэрхэн төлөвлөсөн талаарх дэлгэрэнгүй тайлбарын хамт Нийслэлийн Сонгуулийн хороонд ирүүлжээ.

СЕХ-ноос нийслэлийн Сонгуулийн хороонд нөхөн сонгуулийн нийт санхүүжилтэд **23,855.0** мянган төгрөгийг төлөвлөж, хуваарилсан санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Нийслэлийн сонгуулийн хороонд хуваарилагдсан төсөв

Хүснэгт 1 /төгрөгөөр/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	200,000.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	0.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	120,000.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	170,000.0
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	655,000.0
6	Сургалт, сурталчилгааны зардал	2,090,000.0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	16,200,000.0
8	Бичиг хэргийн зардал	1,100,000.0

9	Шуудан, холбооны зардал	750,000.0
10	Унааны зардал	2,070,000.0
11	Томилолтын зардал	0.0
12	Болзошгүй зардал	500,000.0
	Нийт	23,855,000.0

1.2 Нийслэлийн Сонгуулийн хорооноос Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд зардлыг үндэслэлтэй төлөвлөж хуваарилсан уу?

Нийслэлийн сонгуулийн хороо СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв, хуваарилах, зарцуулах, талан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу болон СЕХ-ны 2023 оны 3/172, 3/240 дүгээр албан бичгүүдийн хавсралтаар ирүүлсэн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримтлан нийслэлийн Сонгуулийн хорооноос Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд **13,835.0** мянган төгрөгийн төсвийг хуваарилсан байна. Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд хуваарилагдсан төсөв

Хүснэгт 2 / төгрөгөөр /

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	100,000.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	0.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	120,000.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	170,000.0
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	655,000.0
6	Сургалт, сурталчилгааны зардал	30,000.0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	10,800,000.0
8	Бичиг хэргийн зардал	250,000.0
9	Шуудан, холбооны зардал	300,000.0
10	Унааны зардал	910,000.0
11	Томилолтын зардал	0.0
12	Болзошгүй зардал	500,000.0
	Нийт	13,835,000.0

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ҮР АШИГТАЙ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН УУ?

Орон нутгийн нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах нийт зардлын 9.3 хувийг хэмнэжээ.

2.1. Нийслэлийн болон Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай хэмнэлттэй зарцуулсан уу?

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэлт 2,221.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос нийслэлийн Сонгуулийн хорооны төсвийг нийт **23,855.0** мянган төгрөгөөр баталж, хуваарилснаас **21,633.5** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт болох **2,221.4** мянган төгрөгийг СЕХ-ны 100900022001 дугаар дансанд татан төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг баримтлан ажилласнаар сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардлыг 2,221.4 мянган төгрөгөөр хэмнэхэд дараах зардлууд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардлыг 0.04 мянган төгрөгөөр;
- Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардлыг 120.0 төгрөгөөр;
- Дүн мэдээ дамжуулах зардлыг 20.0 мянган төгрөгөөр;
- Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлыг 315.0 мянган төгрөгөөр;
- Сургалт, сурталчилгааны зардлыг 40.0 мянган төгрөгөөр;
- Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардлыг 1,200.0 мянган төгрөгөөр;
- Унааны зардлыг 236.4 мянган төгрөгөөр;
- Болзошгүй зардлыг 290.0 мянга төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

2.2. Сонгуулийн зардлын зарцуулалт, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан уу?

Зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтад үндэслэн журмын дагуу бодитоор тайлагнасан байна.

Нийслэл болон Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороод нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.

Нийслэлийн Сонгуулийн хорооны нэгтгэж, тайлагнасан төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар харуулбал:

Сонгуулийн зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл		Хүснэгт 3 / төгрөгөөр/ Нийт дүн	Хэмнэлт
			Нийслэл	СБД		
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	200,000.0	99,960.0	100,000	199,960.0	40.0
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал					-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	120,000.0				120,000.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	170,000.0		150,000	150,000.0	20,000.0
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	655,000.0		340,000	340,000.0	315,000.0
6	Сургалт, сурталчилгааны зардал	2,090,000.0	2,020,000	30,000	2,050 000.0	40,000.0
7	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	16,200,000.0	4,800,000	10,200,000	15,000,000.0	1,200,000.0
8	Бичиг хэргийн зардал	1,100,000.0	850,000	250,000	1,100,000.0	-
9	Шуудан, холбооны зардал	750,000.0	450,000	300,000	750,000.0	-
10	Унааны зардал	2,070,000.0	923,580	910,000	1,833,580.0	236,420.0
11	Томилолтын зардал					-
12	Болзошгүй зардал	500,000.0		210,000	210,000.0	290,000.0
	Нийт	23,855,000.0	9,143,540	12,490,000	21,633,540.0	2,221,460.0

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- > Орон нутгийн нөхөн сонгуулийн зардлыг холбогдох хууль, эрхийн актын дагуу хуваарилсан байна.
- > СЕХ-оос нөхөн сонгуулийн зардлын төсвийг үндэслэлтэй тооцон төлөвлөж, хуваарилсан байна
- > Нийслэл болон Сүхбаатар дүүргийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлыг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв, хуваарилах, зарцуулах , талан гаргах, хяналт тавих журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
- > Нийслэлийн сонгуулийн хорооноос орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах нийт зардлын 9.3 хувийг хэмнэж, зарцуулагдаагүй үлдэгдэл **2,221.4** мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.
- > Нийслэлийн Сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнасан байна.



НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 15160
Утас: (976-11) 32-10-73

2023.08.29 № 24

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуулийг
зохион байгуулан явуулсан үйл ажиллагааны
санхүүгийн тайланд гүйцэтгэлийн аудит хийж,
дүгнэлт ирүүлснийг хүлээн авч танилцлаа.

Саналгүй болно.

ДАРГА



Ү.ГАНБОЛД